



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 615

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай” 51 дүгээр тогтоолын хавсралтад дор дурдсан нэмэлт оруулсугай:

1.1.“2.2.“Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах нээх” хэсэгт 2.2.5. Ажлын хэсэгт томилогдсон албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ” гэж;

1.2.“2.3.9.Сонгон шалгаруулалт зохион байгуулах явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гарсан, гарах нөхцөл бүрдсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлийг олж мэдсэн тохиолдолд нэн даруй эрх бүхий байгууллага, этгээдэд мэдэгдэнэ” гэж;

1.3.“2.3.10.Сонгон шалгаруулалт зохион байгуулахтай холбоотой асуудлаар оролцогч талуудыг төлөөлж буй этгээд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдлийг гаргаж, өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлнэ” гэж.

2. Тогтоолыг нийт төрийн өмчйт хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006590

32-r huraldaan.docx